



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/12

Шивээговь сум

Ур чадварын нэмэгдэл олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрхэлсэн ажилдаа амжилт гарган удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажилласан Санхүүгийн албаны нягтлан бодогч О.Дөлгөөн, Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Ууганбаярт үндсэн цалингийн 20%-иар, жижүүр О.Ууганцэцэгт үндсэн цалингийн 10%-иар, хогны машины жолооч Г.Мөнхжаргалд үндсэн цалингийн 25%-иар тус тус бодож ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Нэмэгдлийг дээр дурдсан хувиар бодож олгохыг нягтлан бодогч /Б.Түвшинжаргал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Баасанбат* Б.БААСАНБАТ

